

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Аймгийн 2026 оны төсөвт татварын
хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах замаар
2,452.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэх
боломжтой байна.**

**АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
САНАЛ, ДҮГНЭЛТ ӨГӨХ**

АУДИТЫН КОД: ГСА-2025/07-6-ШТА-НА

Говьсүмбэр
2025 оны 11 сар

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа Утас: 70543179
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Наранбаяр Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Дарханбат Утас: 70543179
Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Анхтуяа Утас: 70543179
Цахим хаяг: Ankhtuyab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: WWW.AUDIT.MN

Тайланг бэлтгэсэн:**Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар****Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа****Аудитын менежер
Г.Наранбаяр****Ахлах аудитор
Б.Дарханбат****Аудитор
С.Батцэцэг
Б.Соёлмаа****Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж лавлах
зүйл байвал 70543179
дугаарын утсаар
харилцана уу.****ХАЯГ:****Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот****2024 оны 12 дугаар сар****ТОВЧИЛСОН ҮГС 4**

1. АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСӨВТ ТАТВАРЫН ХУРИМТЛАГДСАН ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЗАМААР 2,452.2 САЯ ТӨГРӨГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА. 8

1.1 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ АЙМГИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТЭЙ АГУУЛГЫН ХУВЬД НИЙЦЭЖ БАЙНА. 8

1.3 ТАТВАРЫН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА. 9

1.4 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТАЛСАН ОРЛОГЫН ДООД ХЭМЖЭЭНИЙ ХЯЗГААРЫГ ЗӨРЧИЖ, 2 НЭР ТӨРЛИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТӨСӨЛД 132.5 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛСАН, ТАТВАРЫН ХУРИМТЛАГДСАН ӨР ТӨЛБӨРИЙГ БОДИТОЙ ТООЦОЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА. 10

2. АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УРСГАЛ ЗАРЛАГЫГ 404.2 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА. 16

2.1 ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ, ХУУЛЬ ТОГТООМЖИД БҮРЭН НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА. 16

2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ НИЙТ 2,664.9 САЯ ТӨГРӨГИЙН 6 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА. 20

Дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/34

Чойр

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, “Эрх шилжүүлэх тухай” 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөх” аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга нарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Б.Дарханбат)-д даалгасугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 25-ны өдрийн дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ)-д зөвлөсүгэй.
4. Аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (Б.Дарханбат, Б.Анхтуяа) нарт үүрэг болгосугай.
5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Б.Соёлмаа)-т даалгасугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc
422561083

Товчилсон үгс

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БХНСАХ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НТБТ	Насан туршийн боловсролын төв
СДОА	Сум дундын ойн анги
ОАТ	Орлогын албан татвар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын их хурал
УССТ	Усан спорт сургалтын төв
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЦХБТАОАТ	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

**Аудит
үндэслэл,
бүрэн эрх:**

хийх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвин тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, МУЕА-ын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн мэдүүлсэн Говьсүмбэр аймгийн 2026 оны төсвийн төсөл нь төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахуйц, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байдлаар төсвийн төлөвлөлтийн холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхэд дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудитыг гүйцэтгэсэн.Үүнд:

- Төсвийн төсөлд төсвийн орлогыг хууль тогтоомжийн дагуу боломжит хэмжээнд нэмэгдүүлж төлөвлөсөн эсэх
- Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж, санхүүжилтийг үр нөлөөтэй төсөл арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн эсэх

**Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:**

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Төрийн аудитын тухай
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Татварын хуулиуд
- ✓ Засгийн газрын 2019 оны 312, 2021 оны 160 дугаар тогтоол
- ✓ Сангийн сайдын 2019 оны А/282, 2021 оны А/86 дугаар тушаал
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, гэрээ, эрх зүйн актууд
- ✓ Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох шаардлагатай хууль, дүрэм, журам

**Аудитын хамарсан
хүрээ:**

Аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан орон нутгийн 2026 оны төсвийн төсөл, түүний орлого, зарлагын тооцоо судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн баримт материал, төсвийн шууд захирагчид болон төсвийн төлөвлөлтөд оролцсон холбогдох байгууллагыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Түйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Түйцэтгэлийн аудитын стандарт” “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий

**Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

Хүндрэл бэрхшээл:

Үндсэн мэдээлэл:

аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ыг мөрдөж ажиллалаа. Дээрх стандарт арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг цуглуулж, ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, Б.Анхтуяа, аудитор С.Батцэцэг, Б.Соёлмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан аймгийн ИТХ болон Засаг даргад 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүргүүллээ.

Аудитыг гүйцэтгэх явцад төсвийн төсөлд өөрчлөлт орж байсан нь хүндрэл учруулж байсан.

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “..., түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасан бүрэн эрхийн дагуу аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2026 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт гаргалаа.

Монгол Улсын Их Хурал 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль хэлэлцэн баталсан байна.

Аймгийн Засаг даргаас орон нутгийн 2026 оны төсвийн төслийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн А/1152 дугаартай албан бичгээр 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр ирүүлсэн байна.

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 27,947.3 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь орлогыг 17,820.3 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 5,118.2 сая
- ❖ Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 5,008.7 сая төгрөг байна.

Мөн зарлагыг 27,947.3 сая төгрөгөөр баталсан.

- ❖ Төсвийн суурь зарлага 22,829.1 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 5,118.2 сая

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд УИХ-аас баталсан орлогыг 4,471.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 32,419.0 сая төгрөгийг төсвийн төсөлд тусгасан байна.

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Төсвийн орлого, зарлага	8
Дүрслэл №2	Сангийн яамнаас хянаж УИХ-аар баталсан төсвийг өмнөх онтой харьцуулсан харьцуулалт	8
Дүрслэл №3	Орлогын талаар баримтлах чиглэлүүд	8
Дүрслэл №4	Өмнөх онуудын УИХ-аас баталсан төсвийн суурь зардал, ОНХС-гийн шилжүүлэг	15

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан орлогыг Сангийн яамны хянаж баталсан орлогын доод хязгаартай харьцуулсан байдал	9
Хүснэгт №2	Торгуулийн орлогын хуваарилалт	11
Хүснэгт №3	2025 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (10 дугаар сарын 31-ний байдлаар)	11
Хүснэгт №4	Хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасрахаар тооцоолсон орлого	12
Хүснэгт №5	Орон нутгийн орлого нэмэгдүүлэх санал	13
Хүснэгт №6	Аймгийн 2026 оны төсвийн зарлагын төлөвлөлт	14
Хүснэгт №7	УИХ-аас баталсан суурь зардал болон төсвийн төсөлд төлөвлөсөн зардлын хэмжээг байгууллагаар	15
Хүснэгт №8	Төсөвт хийсэн зохицуулалтыг зардлын ангиллаар	15
Хүснэгт №9	Нэмсэн зардлын 1,566.2 сая төгрөг буюу 35 хувийг “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16
Хүснэгт №10	Засаг даргын хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний харьцуулалт	16
Хүснэгт №11	Орон тооны цомхотголд орж буй албан хаагчдыг ангиллаар	17
Хүснэгт №12	Хөрөнгө оруулалтын төлөвлөлт	19
Хүснэгт №13	Аймгийн 2026 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	19
Хүснэгт №14	Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцээгүй төлөвлөлт	
Хүснэгт №15	Батлагдсан төсвөөс хэсэгчлэн түүвэр хийж төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ний жагсаалт	21
Хүснэгт №16	2026 онд шилжих хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт	22
Хүснэгт №17	Төлөвлөлтийн шаардлага хангаагүй ажлын жагсаалт	23
Хүснэгт №18	Авто замын сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх	24
Хүснэгт №19	2025 оны орон нутгийн төсвийн төслийн аудитаар өгсөн зөвлөмж	26

БҮЛЭГ 1

Аймгийн 2026 оны төсөвт татварын хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах замаар 2,452.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлэх боломжтой байна.

1.1 ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ АЙМГИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТЭЙ АГУУЛГЫН ХУВЬД НИЙЦЭЖ БАЙНА.

Монгол Улсын 2026 оны төсөвт баримтлах бодлогыг “Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн зардлын өсөлтийг хязгаарлаж, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж хувийн хэвшлийг дэмжихийн зэрэгцээ олон нийтийн саналд үндэслэн эрүүл мэнд, боловсролын салбарт түлхүү анхаарна” гэж тодорхойлсон байна.

Говьсүмбэр аймгийн 2026 оны төсвийн төсөл нь аймгийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй агуулгын хувьд нийцэж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-т “Хөгжлийн асуудал хариуцсан аймаг, нийслэлийн байгууллагууд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд суурилсан Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг 9 дүгээр сарын 01-ний дотор боловсруулна”, 18.6-т “Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг жил бүрийн 10 дугаар сарын 01-ний дотор батална” гэж заасан боловч аймгийн 2026 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төсөл батлагдаагүй байгаа тул аймгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулалтын шатанд байгаа бодлогын баримт бичгийн төсөлд үндэслэж нийцсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Төсвийн төслийг боловсруулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагуудын хоорондын уялдаа хангалтгүй, тооцоо судалгаа, мэдээллийн эх сурвалж зөрүүтэй байгаа нь төсвийн төсөл бодлогын баримт бичгүүдтэй бүрэн нийцэж байгаа эсэхийг нэгтгэн дүгнэхэд хүндрэлтэй, хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл бүрэн хангагдахгүй, холбогдох хууль бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

1.2 ТӨСВИЙН ТӨСЛИЙГ САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ХЯЗГААРЫГ БАРИМТЛАН БОЛОВСРУУЛСАН БАЙНА.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах **орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг “жилийн төсвийн хязгаар”** гэнэ.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд нийт орлогыг **32,419.0 сая** төгрөгөөр төсөвлөсөн нь Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дүнгээс **4,471.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлэн боловсруулсан байна.

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд орон нутгийн **8** байгууллага, **190** орон тоотой ажиллан, **19,966.8 сая** төгрөгийн татварын орлогыг бүрдүүлж, үндсэн тэнцлийн алдагдал **5,008.8 сая** төгрөгийг улсын төсвөөс дэмжлэгээр авч, ОНХНС-ийн орлогын шилжүүлгээр **5,118.2 сая**, ОНХС, ОНХО, АЗС-ийн он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдлээс **755.4 сая**, аймаг, сумдын 2025 оны давсан орлого, хэмнэгдсэн зардлаас **1,569.8 сая** төгрөг нийт **32,419.0 сая** төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн 2026 оны төсвийн төслийн суурь зарлагыг Сангийн яамнаас баталсан

хязгаартай харьцуулахад **4,471.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.


Нэмэгдүүлсэн зардлын **40.0 хувийг** хөрөнгө оруулалт, ОНХС, авто замын сангийн зардалд, **22 хувийг** аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд, **38 хувийг** орон нутгийн байгууллагуудын урсгал зардалд тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

1.3 ТАТВАРЫН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

Төсвийн тухай хуулийн 4.1.9-д зааснаар хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг "төсвийн орлого" гэнэ.


Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн нийт орлогын эх үүсвэр, зарлагыг **27,947.3 сая** төгрөгөөр баталсан бөгөөд нийт зарлагын **76 хувийг** төсвийн суурь зарлага эзэлж байна. Үүнд:

Дүрслэл 1.



Сангийн яамнаас хянасан төсвийн төслийг 2025 онтой харьцуулбал:

Дүрслэл 2.



Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2025 төсвийн төсөл

Дүрслэлээс харахад: Өмнөх онтой харьцуулахад суурь орлого 8.1 хувиар өсөж, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 57.3, Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 38.9 хувиар тус тус буурсан байна.

2026 оны орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр 6 чиглэлийг өгсөн боловч төсвийн төсөлд орлогын талаар дараах 3 чиглэлийг баримталж ажиллахаар тусгасан байна. Тухайлбал:

Дүрслэл 3. Орлогын талаар баримтлах чиглэлүүд

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг оны эхнээс жигд хангаж ажиллах, татварын болон бусад өр, төлбөр үүсгэхгүй байх

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч этгээд татварын өр төлбөртэй тохиолдолд тухайн этгээдийн улсын төсвийн санхүүжилтээс татварын өрийг суутган тооцох арга хэмжээ авах

Төрийн байгууллагуудын мэдээллийн уялдаа холбоог сайжруулж, төсвийн орлогын бааз суурийг өргөтгөх, татварын ногдол болон хуримтлагдсан татварын өр төлбөрийг барагдуулах үйл ажиллагаанд анхаарч, холбогдох дэмжлэг үзүүлэн ажиллах

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 төсвийн төсөл

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд тусгасан орлогыг Сангийн яамны хянаж баталсан орлогын доод хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 1.

(сая.төг)

№	ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР	Сангийн яам хянасан орлого	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
	ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	27,947.3	32,419.0	4,471.7
	ТАТВАРЫН БОЛОН ТАТВАРЫН БУС НИЙТ ОРЛОГО	17,820.3	19,966.8	2,146.5
1	ТАТВАРЫН ОРЛОГО	16,450.3	17,865.8	1,415.5
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,370.0	2,101.0	731.0
	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,127.0	10,127.0	-
3	УЛСЫН ТӨСВӨӨС АВАХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	5,008.8	5,008.8	-
4	ОНХС-ИЙН ШИЛЖҮҮЛЭГ	5,118.2	5118.2	-
	БУСАД ОРЛОГО	-	2,325.2	2,325.2
5	2025 ОНЫ ДАВСАН ОРЛОГО, ХЭМНЭГДСЭН ЗАРДАЛ	-	1,569.8	1,569.8
6	ОНХО,ОНХС,АЗС- ОН ДАМЖИН ХИЙГДЭХ АЖЛЫН ЭХНИЙ ҮЛДЭГДЛЭЭС	-	755.4	755.4

Хүснэгтээс харахад 2026 оны төсөвт татварын орлогыг 1,415.5 сая, татварын бус орлогыг 731.0 сая, нийт 2,146.5 сая төгрөгөөр, бусад орлогын эх үүсвэрийг 2,325.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. /Татварын нэр төрлөөр гаргасан нийт орлогын дэлгэрэнгүй судалгааг хавсралт 1-ээс үзнэ үү/

1.4 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТАЛСАН ОРЛОГЫН ДООД ХЭМЖЭЭНИЙ ХЯЗГААРЫГ ЗӨРЧИЖ, 2 НЭР ТӨРЛИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТӨСӨЛД 132.5 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛСАН, ТАТВАРЫН ХУРИМТЛАГДСАН ӨР ТӨЛБӨРИЙГ БОДИТОЙ ТООЦОЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн 2026 оны төсвийн нийт орлогын эх үүсвэрийг **27,947.3 сая** төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн Засаг даргаас 2026 оны төсвийн төсөлд орлогын эх үүсвэрийг **4,471.7 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, **32,419.0 сая** төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна.

Орлогын эх үүсвэрийг дараах байдлаар нэмэгдүүлэн төлөвлөжээ. Үүнд:

1. Суурь орлого: **Нийт 2,146.5 сая**

- ❖ Татварын орлого- 2 нэр төрлийн орлогыг 132.5 сая төгрөгөөр бууруулж, 7 нэр төрлийн орлогыг 1,415.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.
- ❖ Татварын бус орлого- 731.0 сая

2. Бусад орлого: **Нийт 2,325.2 сая**

- ❖ Аймаг, сумдын 2025 оны давсан орлого, хэмнэгдсэн зардал – 1,569.8 сая
- ❖ ОНХС, ОНХО, АЗС-ийн он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдлээс – 755.4 сая

Аймгийн төсвийн тэнцвэржүүлсэн ба тусламжийн орлогыг 4,471.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэхдээ татварын орлогыг 1,415.5 сая, татварын бус орлого- 731.0 сая, аймаг, сумдын 2025 оны давсан орлого, хэмнэгдсэн зардалаас 1,569.8 сая, ОНХС, ОНХО, АЗС-ийн он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдлээс 755.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр тооцсон байна.

Татварын нийт орлогын 16,249.7 сая төгрөг буюу **81.4 хувийг сумдын төсөвт**, 3,717.0 сая төгрөг буюу **18.6 хувийг аймгийн төсөвт** төвлөрүүлэхээр тооцсон байна.

Татварын орлого:

1. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг Сангийн яамны хянасан 700.0 сая төгрөгийг 46.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 746.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.
2. Шууд бус орлогын албан татварыг Сангийн яамны хянасан 220.0 сая төгрөгийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 420.0 сая төгрөгөөр гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
3. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг Сангийн яамны хянасан 127.0 сая төгрөгийг 24.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 151.0 сая төгрөгөөр гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
4. Газрын төлбөрийн орлогыг Сангийн яамны хянасан 680.0 сая төгрөгийг 200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 880.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өрийн үлдэгдлийг төлүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.
5. Улсын тэмдэгтийн хураамжийн орлогыг Сангийн яамны хянасан 90.0 сая төгрөгийг 30.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 120.0 сая төгрөгөөр гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
6. Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийг Сангийн яамны хянасан 30.0 сая төгрөгийг 15.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 45.0 сая төгрөгөөр гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөн байна.
7. Дуудлага худалдааны орлогыг Сангийн яамны хянаагүй бөгөөд 1,033.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь ГХБХБГ-аас дуудлага худалдаанд оруулахаар тооцсон газрыг анхны үнэлгээгээр үнэлэхэд 550.0 сая.төгрөг орох боломжтой тухай албан бичгээр санал ирүүлсэн. Аймгийн зүгээс түүнээс дээш хэмжээгээр орох боломжтой гэж таамагласан, мөн орон нутгийн өмчид бүртгэлтэй зарим эд хөрөнгийг 2026 онд дуудлага худалдаанд оруулах магадлалтай зэргээс шалтгаалж нэмэгдүүлсэн байна.

Харин Сангийн яамнаас хянаж ирүүлсэн дараах 2 нэр төрлийн орлогыг нийт 132.5 сая төгрөгөөр бууруулсан нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалттай нийцэхгүй байна. Үүнд:

1. Үйл ажиллагааны орлогыг Сангийн яамны хянасан 200.0 сая төгрөгөөс 50.0 сая төгрөгөөр бууруулан 150.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого баримталсантай холбоотой байна.
2. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг Сангийн яамны хянасан 335.5 сая төгрөгөөс 82.5 сая төгрөгөөр бууруулан 253.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь ус ашиглагчийн хэрэглээ буурч гүйцэтгэлд үндэслэсэнтэй холбоотой байна.

Татварын бус орлого:

1. Төсөвт байгууллагын өөрийн орлогыг Сангийн яамнаас 20.0 сая төгрөгөөр хянасныг 381.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 401.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь Цөм сүрэг үржлийн

- төв ОНӨААН татан буугдсан тул орлогыг 20.0 сая төгрөгөөр бууруулж, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчилсэнтэй холбоотой үйлчилгээний орлого 300.0 сая, Сангийн яамнаас хянагдаагүй орлогууд буюу Усан спорт сургалтын төв 30.0 сая, Сум дундын ойн анги 50.0 сая, АЗС-ийн орлого 20.0 сая, АЗДТГ-ын орлого 1.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна
2. Хүү торгуулийн орлогыг Сангийн яамнаас 1,200.0 сая төгрөгөөр хянасныг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,500.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөсөнтэй холбоотой байна.
3. Түрээсийн орлогыг Сангийн яамнаас 150.0 сая төгрөгөөр хянасныг 50.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 200.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх онуудын өр төлбөрийг барагдуулахтай холбоотой байна.

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд Малын тоо толгойн албан татварын орлогыг сумд төлөвлөдөг шалтгаанаар төлөвлөөгүй байна. Малын тоо толгойн албан татвар нь орон нутгийн төсвийн орлогын нэг хэсэг тул орлогыг төлөвлөх шаардлагатай.

Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, дуудлага худалдааны орлогыг өмнөх оны гүйцэтгэл, тухайн байгууллагын ирүүлсэн саналд үндэслэн тус тус төлөвлөжээ.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.2¹-т хүү, торгуулийн орлого нь сумын төсвийн орлогын эх үүсвэрт хамаарч байна. 2026 оны төсвийн төсөлд хүү, торгуулийн орлогын 97 хувь буюу 1,450.0 сая төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр, 3 хувь буюу 50.0 сая төгрөгийг Сүмбэр, Шивээговь, Баянтал сумдад төлөвлөсөн нь хуулийн дээрх шаардлагад нийцээгүй байна. 2025 онд Хүү торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн аудитын дүнгээс үзэхэд тухайн сумдын нутаг дэвсгэрт гарсан зөрчлийн дагуу оногдуулсан торгуулийн орлогыг сумдын төсөвт төвлөрүүлдэггүйгээс гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал сумдад батлагдахгүй байна.

Хүснэгт 2		Хүү, торгуулийн орлогын хуваарилалт		(сая.төг)
№	ХҮҮ ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ	2026 оны төсвийн төсөлд төлөвлөсөн дүн	Цагдаагийн торгууль оногдуулсан байдал 2023	Цагдаагийн торгууль оногдуулсан байдал 2024
1	АЙМАГ	1,450.0		
2	СҮМБЭР СУМ	20.0	685.9 сая буюу 88%	1,069.9 сая буюу 90%
3	ШИВЭЭГОВЬ СУМ	20.0	38.2 сая буюу 5%	43.2 сая буюу 4%
4	БАЯНТАЛ СУМ	10.0	54.6 сая буюу 7%	70.9 сая буюу 6%
Нийт		1,500.0	778.8	1,184.0

Иймд хүү, торгуулийн орлогыг тухайн сумаас төвлөрүүлж байгаа хэмжээнд нь сум тус бүрд нь төлөвлөж, сумаас аймагт төвлөрүүлэх орлогын татаасыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүү, торгуулийн орлогыг сумдын орон нутгийн орлогод төлөвлөх нь орлогын бүрдүүлэлтээс хамаарч хуулийн дагуу гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардалдаа зарцуулах боломжтой юм.

Дуудлага худалдааны орлогыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн нэмэгдүүлсэн нь орлогын төлөвлөгөө биелэхгүй байх эрсдэлтэй байна.

Хүснэгт 3. 2025 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (10 дугаар сарын 31-ний байдлаар)

(сая.төг)				
Орлогын нэр төрөл	2025 оны орлогын тодотгосон	2025 оны 10 сарын орлогын	2025 оны 10 сарын гүйцэтгэл	Биелэлтийн хувь

¹ 23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

	төлөвлөгөө	төлөвлөгөө		
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	11,780.8	9,678.7	8,791.7	90.8
Үйл ажиллагааны ОАТатвар	100.0	83.3	119.0	142.8
Суутгагчийн ХХОАТ	430.0	384.5	524.0	136.3
Хөрөнгийн орлого	590.0	491.7	361.5	73.5
Хөрөнгө борлуулсны ОАТатвар	290.0	225.3	194.6	86.4
Хувь хүний ОАТ-ын буцаан олголт	-500.0	-500.0	-500.0	100.0
Малын тоо, толгойд ногдох албан татвар	20.0	10.0	62.4	623.9
ААНОАТатвар	630.0	622.5	608.4	97.7
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	746.0	559.5	684.9	122.4
Бууны албан татвар	6.8	-	1.7	
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	166.0	151.0	148.8	98.5
Улсын тэмдэгтийн хураамж	80.0	66.7	120.6	180.9
Газрын төлбөр	526.0	394.5	401.0	101.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	37.0	37.0	43.2	116.6
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	250.0	215.0	203.8	94.8
Дуудлага худалдааны орлого	873.4	873.4	919.3	105.3
Ан амьтны нөөц ашигласны албан төлбөр	54.1	54.1	83.3	154.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	650.0	447.3	152.8	34.2
Түрээсийн орлого	190.3	158.6	89.1	56.2
Хүү, торгуулийн орлого	1,820.0	1,734.0	1,434.0	82.7
Бусад орлого	-	-	10.7	
НИЙТ ДҮН	18,740.3	15,686.8	14,454.7	92.1

Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 төсвийн төсөл

Хүснэгтээс харахад: Хөрөнгийн орлого, хөрөнгө борлуулсны ОАТ, ус рашааны нөөц ашигласны төлбөр, түрээсийн орлого, хүү торгуулийн гүйцэтгэл 34.2-86.4%-тай байна.

Аймгийн Татварын газраас 2025 оны жилийн эцсийн ХБГ-ийг татварын 6 орлогын төлөвлөгөө 0.4-61.1%-иар тус тус тасрах тооцоолол ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 4. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасрахаар тооцоолсон орлого (хувиар)

№	Татварын орлогын нэр, төрөл	Хувь
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	10.5
2	Хөрөнгийн орлого	23.4
3	Хөрөнгө борлуулсны орлого	31.0
4	ААНОАТ	0.4
5	АТБӨЯХАТ	9.0
6	Ус рашааны нөөц ашигласны төлбөр	61.1
Дундаж хувь		0.4-61.1%

Эх сурвалж: Татварын газрын ирүүлсэн тооцоолол

Аймгийн Татварын газраас 2025 оны татварын орлогын хүлээгдэж буй гүйцэтгэлийг 1,613.1 сая төгрөгөөр тасрах тухай урьдчилсан мэдээг ирүүлсэн бол СТСХ-ээс 303.4 сая төгрөгөөр давж биелэхээр тооцоолсон нь тухайн байгууллагуудын хүлээгдэж буй гүйцэтгэлийн мэдээ нийт 1,916.5 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй, төлөвлөлтийг бодит мэдээ судалгаанд үндэслэн хийгээгүйтэй холбоотой байна.

ОРЛОГО НЭМЭГДҮҮЛЭХ САНАЛ:

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд орлогыг нийт 2,452.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.

Татварын орлогыг нэмэгдүүлэх санал:

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар Төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах **орлогын доод хэмжээ**, зарлагын дээд хэмжээг **"жилийн төсвийн хязгаар"** гэнэ.

Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөлд Сангийн яамнаас хянаж, УИХ-аар баталсан орлогын төлөвлөгөөг **132.5 сая төгрөгөөр** буюу үйл ажиллагааны ОАТ-ыг 50.0 сая төгрөгөөр, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 82.5 сая төгрөгөөр тус тус бууруулж төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.9² 41 дүгээр зүйлийн 41.2.1³-т заасныг зөрчсөн тул **татварын орлогыг 132.5 сая төгрөгөөр буцаан нэмэгдүүлэх, орлогын төлөвлөлтийг үндэслэлтэй тооцоолох саналыг хүргүүлж байна.**

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг сайжруулж татварын ногдол болон хуримтлагдсан татварын өр төлбөрийг барагдуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9, 41 дүгээр зүйлийн 41.2.1.⁴, Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁵, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5⁶-д заасныг зөрчсөн тул 2022-2024 оны хооронд хуримтлагдсан **5 орлогын 2,319.7 сая төгрөгийн өр төлбөрийг** барагдуулж, **татварын орлогын эх үүсвэрийг** нэмэгдүүлэх саналыг хүргүүлж байна.

Төрийн аудитын байгууллагаас жил бүр гүйцэтгэж буй аймгийн Нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд үндэслэн төсвийн орлогын гүйцэтгэлд хийсэн судалгаагаар 2022-2024 онд 4 нэр, төрлийн татварын орлого жил бүр тасарч, өр төлбөр хуримтлагдсаар ирсэн байна.

Судалгаанд үндэслэн тооцсон орлого нэмэгдүүлэх саналыг татварын орлогын нэр төрлөөр харуулбал:

Хүснэгт 5 Орон нутгийн орлого нэмэгдүүлэх санал (сая.төг)

Орлогын нэр төрөл	Өмнөх онуудад төвлөрүүлээгүй татварын дүн			Нийт дүн
	2022 он	2023 он	2024 он	
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	180.4	93.2	158.3	431.9
Малын тоо толгойн албан татвар	74.3	57.9	69.6	201.8
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	213.8	36.5	107.1	357.3
Түрээсийн орлого	18.0	8.8	11.7	38.5
НИЙТ ДҮН	486.4	196.4	346.7	1,029.6

Эх сурвалж: ТЕЗ-ийн 2022-2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Иймд өмнөх онуудад хуримтлагдсан татварын өр төлбөрийг барагдуулж, төсөвт төвлөрүүлэх замаар **4 нэр, төрлийн** татварын орлогыг **1,029.6 сая** төгрөгийн орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтой байна

² 4.1.9."төсвийн орлого" гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг;

³ 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

⁴ 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

⁵ 7.1.Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө",

⁶ 10.5.Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно"

2025 онд хийгдсэн “Газар эзэмших эрх олголт, түүний үр дүн”-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1⁷ дэх хэсэг, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5⁸ дахь хэсэгт заасан иргэд, ахуй нэгжийн газрын төлбөр төлөх гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс 6 ААНБ-ын 2020-2025 онд үүссэн өндөр дүнтэй, хуримтлагдсан өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2026 оны орон нутгийн төсөвт өмнөх онуудад хуримтлагдсан татварын өр төлбөрийг *газрын төлбөрийн орлогыг нийт 1,290.1 сая* төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлж байна.

⁷ 7.1. Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө.

⁸ 5.Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

БҮЛЭГ 2

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд урсгал зарлагыг 404.2 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

2.1 Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, хууль тогтоомжид бүрэн нийцүүлж төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-т зааснаар “Төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг” хэлнэ.


Аймгийн 2026 оны төсвийн зарлагыг 32,419.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь 2025 оны тодотгосон зарлагын төлөвлөгөөнөөс 39,064.8 сая төгрөг буюу **17 хувиар** бууруулж төлөвлөсөн байна.

Төсвийн төслийн нийт зардлын 7,487.8 сая буюу **23 хувийг** хөрөнгө оруулалтын зардал, 24,931.2 сая буюу **77 хувийг** урсгал зардал эзэлж байна.

Монгол Улсын 2026 оны Төсвийн тухай хуулиар аймгийн 2026 оны төсвийн нийт зарлага **27,947.3** сая төгрөгөөр хянагдаж батлагдсан байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь зарлагыг 22,829.1 сая /Үүнээс 5,008.8 сая нь санхүүгийн дэмжлэг/
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлэг 5,118.2 сая

Дүрслэл 4. Өмнөх онуудын УИХ-аас баталсан төсвийн суурь зардал, ОНХС-гийн шилжүүлгийг харьцуулж үзвэл: (сая.төг)



Дүрслэлээс харахад: Төсвийн суурь зардал өмнөх оноос 5,380.5 сая буюу **19.07** хувиар, ОНХС-гийн шилжүүлэг 3,256.1 сая буюу **38.9** хувиар, нийт 8,636.6 сая төгрөг буюу **23.6** хувиар буурсан байна.

УИХ-аар батлагдсан 27,947.3 сая төгрөгийн төсвийн зарлагыг ТЕЗ-аас 4,471.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 32,419.0 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн төсөлд Төрийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулахаар 2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын бүтцийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6		“Аймгийн 2026 оны төсвийн зарлагын төлөвлөлт”	
		(сая.төг)	
Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
Орон нутгийн суурь зардал	22,829.1	27,268.3	4,439.2
ОНХС-гийн зардал	5,118.2	5,150.7	32.5
Нийт дүн	27,947.3	32,419.0	4,471.7

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, Сангийн яамнаас ирүүлсэн суурь зардлын төлөвлөгөө)

Аймгийн Засаг даргаас 2026 оны орон нутгийн төсвийн төслийн нийт зарлагад дараах байдлаар өөрчлөлт оруулан төлөвлөж, санал ирүүлсэн байна. Үүнд:

Хүснэгт 7. УИХ-аас баталсан суурь зардал болон төсвийн төсөлд төлөвлөсөн зардлын хэмжээг байгууллагаар нь харуулбал: (сая.төг)

№	Байгууллагын нэр	УИХ-аар баталсан	Нэмсэн	Хассан	Төсвийн төслийн дүн	Зөрүү
1	Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	548.9	155.5	-	721.4	172.5
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	442.4	-	20.0	422.5	-20.0
3	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	612.1	33.7	136.0	509.9	-102.2
4	Аймгийн Засаг даргын Тамгын газар	4,369.4	1,467.5	664.1	5,172.7	803.4
5	Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	3,887.8	709.3	522.4	4,074.7	186.9
6	Хотын захирагчийн алба	447.8	504.1	4.1	947.8	500.0
7	Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба	328.6	14.9	28.1	315.4	-13.2
8	Цөм сүргийн хөгжлийн төв	208.7	-	178.7	30.0	-178.7
9	Аймаг нийслэлийн Засаг дарга Ерөнхий данс /Мал эмнэлэг/	41.4	-	0.0	41.4	-0.0
10	Орон нутгийн өмчийн газар	368.4	19.5	153.5	234.4	-134.0
11	Худалдан авах ажиллагааны газар	267.0	13.4	56.3	224.1	-42.9
12	Ойн анги	306.9	104.1	4.9	406.1	99.2
13	Хот байгуулалт, тохижилт	735.0	465.0	-	1,200.0	465.0
14	Байгаль орчны газар	478.3	171.0	3.9	645.4	167.1
15	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	2,162.2	40.0	59.6	2,142.6	-19.6
16	Биеийн тамир спорт	839.3	244.4	211.3	872.4	33.1
17	Соёл урлаг	1,017.6	-	478.1	539.5	-478.1
18	Сургуулийн өмнөх боловсрол	1,171.7	-	57.2	1,114.5	-57.2
19	Ерөнхий боловсрол	2,044.2	846.4	-	2,890.6	846.4
20	Мэргэжлийн боловсрол	730.4	73.7	3.1	801.0	70.6
21	Нийгмийн халамж	39.9	0.0	-	39.9	0.0
22	Ахмадын хороо	186.9	25.0	-	212.0	25.0
23	Хүүхэд хамгаалал	-	73.0	-	73.0	73.0
24	Улсын төсвийн байгууллагын ТЗ-ны албан хаагч нарт ОНН-20 хувь	-	1,000.0	-	1,000.0	1,000.0
25	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан	-	300.0	-	300.0	300.0
26	Төрийн болон орон нутгийн өмчийн засвар, арчилгаа	959.2	-	959.2	-	-959.2
27	Орон нутгийн хөрөнгө оруулалт	-	1,469.7	-	1,469.7	1,469.7
28	Авто замын сан	635.0	232.5	-	867.5	232.5
	Дүн	22,829.1	7,962.6	3,540.5	27,268.3	4,439.2
1	Орон нутгийн хөгжлийн сан	5,118.2	32.5	-	5,150.8	32.5
	Дүн	5,118.2	32.5	-	5,150.8	32.5
	Нийт	27,947.3	7,995.2	3,540.5	32,419.0	4,471.7

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, түүнд хийсэн аудитын тулган баталгаажуулалтын ажлын баримт)

Хүснэгтээс харахад: УИХ-аар баталсан төсвийг **4,471.7 сая** төгрөгөөр нэмж зохицуулалтыг хийсэн байна.

Хүснэгт 8. Төсөвт хийсэн зохицуулалтыг зардлын ангиллаар харуулбал: (сая.төг)

№	Зардлын эдийн засгийн ангилал	Мөнгөн дүн	Эзлэх хувь
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	284.5	6%
2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34.5	1%
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	523.0	12%
4	Хангамж, бараа материалын зардал	57.7	1%
5	Нормативт зардал	5.0	0%
6	Эд хогшил, урсгал засварын зардал	-18.9	0%
7	Томилолт, зочны зардал	7.2	0%
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,566.2	35%
9	Бараа үйлчилгээний бусад зардал	992.7	22%

10	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-55.5	-1%
11	Бусад зардал	1,075.4	24%
Нийт нэмсэн хассан зөрүү		4,471.7	100%

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, түүнд хийсэн аудитын тулган баталгаажуулалтын ажлын баримт)

Хүснэгт 9 Нэмсэн зардлын 1,566.2 сая төгрөг буюу 35 хувийг “Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж” (сая.төг)

№	Зардлын зүйл	Мөнгөн дүн
1	Улсын төсвийн байгууллагын албан хаагчдад олгох ОН-20%	1,000.0
2	Аймгийн Засаг даргын нөөц	366.5
3	Хот захирагчийн албаны гэрээт цалин	200.0
Нийт дүн		1,566.5

1,075.4 сая төгрөг буюу 24 хувийг ОНТХО, ЖДҮДС-ийн зардал, 992.7 сая төгрөг буюу 22 хувийг “Бараа үйлчилгээний бусад зардал”, 523.0 сая буюу 13 хувийг “Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал”, 319.0 сая буюу 6 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшил эзэлж байна.

Хүснэгт 10. Засаг даргын хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний харьцуулалт (сая.төг)

№	Салбар	2026	2025 оны төсөв	Зөрүү
1	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх арга хэмжээ	120.0	132.0	(12.0)
2	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын хөгжлийг дэмжих арга хэмжээ	80.0	88.0	(8.0)
3	Боловсролыг дэмжих арга хэмжээ	115.0	270.0	(155.0)
4	Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ	25.0	20.0	(5.0)
5	Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үйл ажиллагаа	35.0	20.0	15.0
6	Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр арга хэмжээ	110.0	90.0	20.0
7	Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх арга хэмжээ	102.0	53.0	42.0
8	Гамшгаас хамгаалах арга хэмжээ	20.0	75.8	(55.8)
9	“Цахим говьсүмбэр” хөтөлбөр, арга хэмжээ	60.0	70.0	(10.0)
10	Агаар орчны бохирдлыг бууруулах арга хэмжээ	13.0	38.0	(25.0)
11	Хүнс, хоршоо, мал аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээ	20.0	50.0	(30.0)
12	Орон нутгийн хамгаалалтын зардал	20.0	30.0	(10.0)
13	Игэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ		30.0	(30.0)
14	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ		10.0	(10.0)
15	Жендерийн эрх эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ		19.0	(19.0)
16	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах арга хэмжээ		5.0	(5.0)
17	Эрүүл хүнс, Эрүүл монгол хүн арга хэмжээ		18.0	(18.0)
НИЙТ ДҮН		720.0	1,018.8	- 298.8

(Эх сурвалж: Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл, түүнд хийсэн аудитын тулган баталгаажуулалтын ажлын баримт)

Хүснэгтээс харахад: 2026 оны төсвийн төсөлд засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний зардлыг өмнөх оноос 5 арга хэмжээ, **298.8 сая** төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГЫГ БУУРУУЛАХ САНАЛ:

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд нийт 404.2 сая төгрөгийн зарлагыг бууруулах дараах саналыг гаргаж байна.

- Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17 “Захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно”, Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын хавсралтаар “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 2

дугаар зүйлийн 2.3⁹-т заасны дагуу орон нутгийн нэмэгдлийг тооцож төлөвлөхдөө зөвхөн аймгийн ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдад улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 60 хувь, нийт 80 хувиар, ТЕЗ-д хамаарах орон нутгийн бусад төрийн байгууллагын албан хаагчдад 40 хувиар олгохоор тооцож ялгамжтай байдлаар төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹⁰, 31.1.3¹¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7¹², дэх заалтуудтай нийцэхгүй байгаа тул орон нутгийн төсвийн байгууллагуудад олгох орон нутгийн нэмэгдлийг Төсвийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн нийтлэг байдлаар 60 хувиар тооцож төлөвлөх боломжтой байна.

Ингэснээр цалингийн зардалд төлөвлөсөн орон нутгийн нэмэгдлийг **238.9** сая төгрөгөөр бууруулах саналыг оруулж байна. /аймгийн ИТХ-аас 33.1 сая, ЗДТГ-аас 205.8 сая/

2. АИТХ-д Бараа ажил үйлчилгээний бусад зардлыг хүрэх үр дүнг тодорхойлоогүй, тооцоо судалгаагүй, үндэслэлгүйгээр **29.3 сая** төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасныг зөрчсөн тул зардлыг хасах
3. Орон нутгийн байгууллагуудад мэргэжлийн үйлчилгээний төлбөрийн нийт **136.0 сая** төгрөгийг үндэслэлгүй, тооцоо судалгаагүй төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 31 дүгээр зүйлийн 31.1.3-д заасныг зөрчсөн тул хасах

ТӨСВИЙН ҮР АШГИЙГ САЙЖРУУЛАХ, ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦҮҮЛЭХ САНАЛ:

Аймгийн 2026 оны төсвийн төсөлд бүтэц, орон тоог өөрчлөх, цомхотгохдоо чиг үүргийн шинжилгээ хийх, орон тоо буурсан албан хаагчдад олгох 66.6 сая төгрөгийн тэтгэмжийг төсөвт төлөвлөх, ажил олгогчийн санаачилгаар орон тоог бууруулахыг хориглосон албан хаагчдын эрх ашгийг харгалзаж үзэх хууль тогтоомжид нийцүүлэх дараах саналыг хүргүүлж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай “Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоол”-ын 1 дэх хэсэг, Монгол улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд заасны дагуу төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулахаар шийдвэрлэсэн.

Говьсүмбэр аймгийн хувьд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар нийт 180 орон тооны 8,892.1 сая төгрөгийн цалин хөлсийг баталсан байна. Аймгийн 2026 оны төсвийн төсөлд одоо ажиллаж буй 246 орон тоог 55-аар, цалин хөлсний зардлыг 2,017.6 сая төгрөгөөр бууруулж 190 орон тоонд 9,064.6 сая төгрөгийн цалин хөлс олгохоор төлөвлөжээ.

Хүснэгт 11. Орон тооны цомхотголд орж буй албан хаагчдыг ангиллаар харуулбал (сая.төг)

№	Төрийн албаны ангилал	Тоо	Үүнээс сул байгаа орон тоо
1	Төрийн захиргаа	19	14
2	Төрийн үйлчилгээ	29	1
3	Төрийн улс төр	1	0
4	Гэрээт ажилтан	2	0
5	Сул орон тоо /ЦСҮТ/	4	4
Нийт		55	19

⁹ 2.3.Орон нутагт ажилласны нэмэгдлийг тухайн орон нутгийн хөгжлийн бодлогын хүрээнд орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид нэмж олгох асуудлыг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвтөө тусган шийдвэрлэж болно. (Засгийн газрын 2024 оны 171 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

¹⁰ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

¹¹ 31.1.3.жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

¹² 4.1.7. бодитой байх

(Эх сурвалж: Аймгийн 2026 оны төсвийн төсөл)

Хүснэгтээс харахад: Төрийн захиргааны ангиллаас 19 орон тоог /үүнээс 14 орон тоо нь сул/, Төрийн үйлчилгээний ангиллаас 29 орон тоог тус тус цомхотгосон /үүнээс 1 орон тоо сул/ байна. Цомхотголоор хасагдаж буй орон тооны 53 хувь нь ТҮМ, ТҮ, гэрээт ангилалд хамаарах хамгийн бага цалин хөлсөөр ажилладаг албан хаагчид байна.

Аудитаар орон тооны цомхотголыг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг шалгахад дараах зөрчил илэрлээ.

1. Сангийн сайдын 2025 оны 11 сарын 14-ний өдрийн 10180 дугаартай “Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-г аймгийн ТЕЗ-д хүргүүлсэн байна. Уг чиглэлийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах байгууллагуудын чиг үүрэгт дүн шинжилгээ хийн, бүтэц зохион байгуулалтын оновчтой хувилбарыг сонгож, нэгтгэн зохион байгуулах замаар УИХ-аас баталсан Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд аймгийн суурь зарлагад туссан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан үйл ажиллагаагаа явуулах” гэж заасан боловч 11 төсвийн байгууллагад дээрх чиглэлийн дагуу чиг үүргийн шинжилгээ хийгээгүй байна. **Энэ нь Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолыг зөрчсөн бөгөөд чиг үүргийн шинжилгээ хийхгүйгээр бүтэц, орон тоо өөрчлөх, бууруулах нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах эрсдэлтэй байна.**
2. ТҮМ, ТҮ ангиллын үндсэн орон тоонд ажиллаж буй 19 төрийн үйлчилгээний ажилтныг гэрээт ажилтнаар ажиллуулахаар төлөвлөж орон тоог бууруулсан боловч тухайн ажилтнуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1¹³, 82 дугаар зүйлийн 82.1¹⁴-т заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсны тэтгэмжийн зардал **66.6 сая төгрөгийг** төсөвт тооцож төлөвлөөгүй байна. Энэ нь цомхотголоор үндсэн орон тоо буурч гэрээт ажилтан болсон тул өрхийн орлого буурах, нийгмийн баталгааг алдагдуулах, буруу шийдвэр гаргасан этгээд шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах зэрэг эрсдэлтэй байна.
3. Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.1¹⁵-т заасныг зөрчиж 0-3 насны хүүхэдтэй 2 эхийн ажлын байрны орон тоог бууруулахаар төлөвлөсөн байна.

Иймд төсөв боловсруулах удирдамжид заасан чиг үүргийн судалгааг хийсний үндсэн дээр бүтэц, орон тооны өөрчлөлтийг хийх, үндсэн ажилтнаас орон тооны цомхотголоор чөлөөлөгдөж буй албан хаагчдад олгох **66.6 сая төгрөгийн тэтгэмжийг** хуульд заасны дагуу бүрэн тооцож олгох, 0-3 насны хүүхэдтэй албан хаагчдын орон тоог бууруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд зөвшилцөх зэргээр хууль тогтоомжид нийцүүлэх саналыг аймгийн Засаг даргад хүргүүлж байна.

2.2 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлагад бүрэн нийцээгүй нийт 2,664.9 сая төгрөгийн 6 хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Ерөнхий мэдээлэл:

ТЕЗ-аас хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх орлогын эх үүсвэрийг 2025 оны шилжих ажлын үлдэгдэл санхүүжилтээс 378.7 сая, авто замын хураамжийн орлогоос 20.0 сая, ОНХНС-гийн орлогын шилжүүлгээс 5,118.2 сая, төрийн болон орон нутгийн өмчийн засвар

¹³ 80.1.1.аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн;

¹⁴ 82.1.Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:

¹⁵ 135.1.Энэ хуулийн 80.1.4, 80.1.5, 80.1.6-д заасан болон аж ахуйн нэгж, байгууллага татан буугдсанаас бусад тохиолдолд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх /ганц бие эцэг/-ийн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажил олгогчийн санаачилгаар цуцлахыг хориглоно.

арчилгааны зардлаас 959.2 сая, авто замын сангийн санхүүжилтээс 635.0 сая нийт 7,111.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 12. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт (сая.төг)

Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	2026 оны төсвийн төсөл	Зөрүү
ОНХС-гийн зардал	5,118.2	5,150.7	32.5
ОНХО-ын зардал	0	1,469.6	1,469.6
Авто замын сангийн зардал	635	867.5	232.5
Нийт дүн	5,753.2	7,487.8	1,734.6

(Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл)

Говьсүмбэр аймгийн 2025 оны төсвийн төсөлд аймгийн ОНХО, ОНХС, Авто замын сан, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлж шинээр хэрэгжүүлэхээр 10,885.0 сая төгрөгийн 60 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан бол 2026 оны төсвийн төсөлд 4,318.4 сая төгрөгийн 23 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Хүснэгт 13. “Аймгийн 2026 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ” (сая.төг)
/сумын ОНХС-д хуваарилагдсан дүн ороогүй/

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Авто замын сан	БХНСАХ	Нийт
1	Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажил	1,760.1	772.8	245.0	35.0	2,912.9
2	Их засвар					
3	Тоног төхөөрөмж	100.0				100.0
4	Зураг төсөв		186.4			186.4
5	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ			410.0	53.5	463.5
6	Шилжих хөрөнгө оруулалт	32.5	510.7	212.4		755.6
	Дүн	1,892.6	1,469.9	867.4	88.5	4,318.4

(Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн 2026 оны төсвийн төсөл)

Хүснэгтээс харахад: Нийт санхүүжүүлэхээр тооцсон төсөвт өртгийн 2,912.9 сая төгрөг буюу **74 хувийг** шинээр эхлэх хөрөнгө оруулалтын ажилд зарцуулахаар төлөвлөжээ.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт

Улсын Их Хурлаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийг 5,118.2 сая, төгрөгөөр баталсан бөгөөд үүнээс сумдад 3,258.1 сая төгрөгийг хуваарилж, аймгийн ОНХС-гийн шинээр эхлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний зардалд 1,860.1 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Төсвийн төсөлд тусгасан аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Барилгын тухай хууль болон Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д заасан шаардлагыг хангаагүй байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцээгүй төлөвлөлт: /Шинээр эхлэх 1,860.1 сая төгрөгийн 6 ТАХ/Хүснэгт 14. **Орон нутгийн хөгжлийн сангийн журамд нийцээгүй төлөвлөлт** (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хамрах салбар	Эхлэх/дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжүүлэх дүн
1. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт					
1.1	Тагт, Гашууны эгнээний 0.4кВ цахилгаан шугамын өргөтгөл	Дэд бүтэц	2026	200.0	200.0
1.2	Баянтал суманд баригдах спорт заалны өргөтгөл	Боловсрол	2026	600.0	600.0
1.3	Усан бассейны үлдэгдэл ажил /сантехник, агааржуулалт, фитнес заал, гадна пандус/	Биеийн тамир спорт	2026	310.1	310.1
1.4	Сүмбэр суманд автозамын дагуу гэрэлтүүлэг, явган замын ажил (Өгөөж)	Хот тохижилт	2026	200.0	200.0
1.5	Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн цахилгаан хангамж (Зураг төсөв, цахилгаан, хангамжийн ажил)	Дэд бүтэц	2026	450.0	450.0
Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын дүн				1,760.1	1,760.1
2 Тоног төхөөрөмж					
2.1.	Боловсролын байгууллагын техник, тоног төхөөрөмж	Боловсрол	2026	100.0	100.0
Тоног төхөөрөмж			2026	100.0	100.0
Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын нийт дүн				1,860.1	1,860.1

- Журмын 4 дүгээр зүйлийн 4.1.6.¹⁶-т заасны дагуу хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардал, орон нутгийн төсөвт нөлөөлөх талаар тооцоо хийж дүгнэлт гаргаагүй.
- Журмын 7 дугаар зүйлийн 7.1¹⁷-т заасны дагуу ОНХС-г олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгуулаагүй.
- Журмын 7 дугаар зүйлийн 7.2¹⁸-т заасны дагуу сумын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй хөрөнгө оруулалтын ТАХ-ний жагсаалтыг хүлээн авч эрэмбэлээгүй.
- Журмын 7 дугаар зүйлийн 7.4¹⁹-т заасны дагуу аймгийн Засаг дарга баталгаажсан саналыг олон нийтэд ил тод мэдээлээгүй.
- Журмын 7 дугаар зүйлийн 7.6²⁰-т заасны дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй.

¹⁶ 4.1.6. Аймаг, нийслэлийн ОНХС-ийн ажлын хэсэг нь тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр санал болгож буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлтэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардлыг тооцож, орон нутгийн төсөвт нөлөөлөх нөлөөллийн талаарх дүгнэлтийг гаргасан байх

¹⁷ 7.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийг байгаль орчин, газрын харилцаа, хөдөө аж ахуй, санхүү, төрийн сангийн асуудал хариуцсан ажилтан, холбогдох хэлтсийн албан тушаалтнууд, иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргаар ахлуулсан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна.

¹⁸ 7.2. Аймаг, нийслэл нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч ОНХС-ийн ажлын хэсгээр хянаж эрэмбэлүүлнэ.


¹⁹ 7.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр дамжуулан танилцуулна.

²⁰ 7.6. Ажлын хэсэг хэлэлцүүлгийн үр дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг ОНХС-ийн УМС-ийн маягтын дагуу хэвлэж жил бүрийн 8 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

- Журмын 7 дугаар зүйлийн 7.7²¹-т заасны дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл, жагсаалтыг орон нутгийн төсвийн төсөлд хавсаргаж ирүүлээгүй.

2. Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй хөрөнгө оруулалтын төсөл: /жүрамд нийцээгүй 1,050.0 сая төгрөгийн 2 TAX/

- “Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн цахилгаан хангамж (Зураг төсөв, цахилгаан хангамжийн ажил)-450.0 сая
- Баянтал суманд баригдах спорт заалны өргөтгөл-600.0



Баянтал суманд баригдах спорт заалны өргөтгөлийн ажил 2024.07.01-ний өдөр барилга хөгжлийн төвд 1.9 тэрбум төгрөгөөр магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй бөгөөд дараах байдлаар төлөвлөсөн. Тэнхлэгээрээ 36*18м-н хэмжээтэй, цутгамал төмөр бетон баганан суурь бүхий төмөр бетон каркасан 36см-н дүүргэгч блокон хана, металл дам нуруу, сендвичэн хучилттай, гадна ханыг 100см-н хөөсөнцөр хавтангаар дулаалж, металжсан хавтангаар өнгөлөх

2024 онд Баянтал сумын ОНХС-гийн 590.5 сая төгрөгийн хөрөнгөөр уг барилгын суурь, дам нуруу, шал зэргийг гүйцэтгүүлж хүлээн авсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн аудитаар уг ажлын гүйцэтгэл, чанар үр дүнг шалгахад дараах нөхцөл байдал илэрсэн. Үүнд:

1 дүгээр давхрын хойд хэсгийн багана дам нуруу хийгээгүй, суур, шалны нягтруулалт хангалтгүй, шал тэгш хэмтэй бус, зарим газраараа овойсон бол зарим хэсгээр суулт өгч хэв гажилт үүссэн. Шалны дулаалгын хөөсөнцөр тэгш хэмтэй бус зарим хэсэгт газарт хүрэлцэхгүй, ус нэвтэрсэн, арматурыг хамгаалсан ороолт салхины нөлөөгөөр хийсэж арматур ус чийг авч зарим хэсэгт зэвэрсэн. Захиалагч ил далд ажлын актыг баталгаажуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

2026 оны төсвийн төсөлд хөөсөнцөр дулаалгатай төмөр сендвич хавтангаар гадна ханыг хийх, ердийн тоосгон 250мм хана хийх зэргээр уг ажлын хийц, ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулан 600.0 сая төгрөгөөр зөвхөн барилгын ажлыг дуусгахаар төлөвлөсөн бөгөөд үүнээс шалтгаалан 2024 онд магадлалаар баталгаажсан зураг, төсвийг баримтлах боломжгүй болжээ.

Энэ нь зураг төсөв боловсруулах ажлын даалгаврыг боловсруулахдаа /цутгамал төмөр бетон хийцлэлтэй байхаар төлөвлөсөн/ орон нутгийн эдийн засгийн боломж, санхүүгийн чадавхийг харгалзаж үзэлгүйгээр төлөвлөлт хийсэнтэй холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²², Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3²³, 13.5²⁴, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5²⁵, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.3²⁶, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын

²¹ 7.7 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн нэгдсэн жагсаалтыг хурлын тэмдэглэл болон орон нутгийн төсвийн төсөлд тусган аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ

²² 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²³ 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

²⁴ 13.5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ.

²⁵ 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

²⁶ 4.3.3 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.3²⁷ -т заасныг тус тус зөрчсөн байна.

3. Магадлалаар баталгаажсан төсвөөс хэсэгчлэн зардлын түүвэр хийж төлөвлөсөн дараах хөрөнгө оруулалтын ажлууд байна. Үүнд:

Хүснэгт 15. “Батлагдсан төсвөөс хэсэгчлэн түүвэр хийж төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ТАХ-ний жагсаалт” (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөг	Магадлалаар баталгаажсан зураг, төсвийн	
1. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт			Батлагдсан огноо, дугаар	Төсөвт өртөг
1.1	Тагт, Гашууны эгнээний 0.4кВ цахилгаан шугамын өргөтгөл	200.0	2024.07.01 436/2024	322.4
1.2	Усан бассейны үлдэгдэл ажил /сантехник, агааржуулалт, фитнес заал, гадна пандус/	310.1	2025.03.31 365/2025	1,164.9
1.3	Сүмбэр суманд автозамын дагуу гэрэлтүүлэг, явган замын ажил (Өгөөж)	200.0	2024.12.13 547/2024	2,155.9
Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын дүн		710.1		3,643.2

(Эх сурвалж: Магадлалаар батлагдсан зураг төсөв)

Хүснэгтээс харахад: Магадлалаар баталгаажсан 3,643.2 сая төгрөгийн төсөвтэй 4 хөрөнгө оруулалтын ажлаас 710.1 сая төгрөгийн 3 ажлыг хэсэгчлэн гүйцэтгэхээр төлөвлөжээ. Магадлалаар баталгаажсан төсвөөс хэсэгчлэн гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, төсөвт өртгийг хэрхэн тооцож түүвэрлэсэн нь тодорхойгүй зураг төсөв зохиогч болон мэргэшсэн төсөвчнөөр хяналтын төсөв хийлгээгүй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлттэй холбоотой аудитын санал, зөвлөмж:

- Журмын 4 дүгээр зүйлийн 4.1.6. -т заасны дагуу **1,860.1 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй 6 хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөлттэй холбоотой асуудал болон хөрөнгийн ашиглалтын урсгал зардал, орон нутгийн төсөвт нөлөөлөх талаар тооцоо хийж дүгнэлт гарган төсвийн төсөлд хавсарган **ИТХ-д танилцуулж төсвийн төлөвлөлтийг сайжруулах**
- Батлагдсан зураг төсөвгүй “Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн цахилгаан хангамж (Зураг төсөв, цахилгаан хангамжийн ажил)” - **450.0 сая төгрөгийн** хөрөнгө оруулалтын **төслийг хасах**, шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөх
- Баянтал суманд баригдах спорт заалны өргөтгөл-**600.0 сая төгрөгийн** хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар баталгаажуулах/зураг төсөв зохиогчтой зөвшилцөх/, өмнө хийгдсэн ажлын чанарыг хянах, цаашид үргэлжлүүлж барихад холбогдох барилгын норм, дүрэм зөрчигдөхгүй талаар **мэргэжлийн байгууллагуудаар дүгнэлт гаргуулан төсвийн хөрөнгийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах**
- Магадлалаар баталгаажсан төсвөөс зардлын түүвэр хийж хэсэгчлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн **710.1 сая төгрөгийн 3 хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг баталгаажуулж, төсвийн хөрөнгийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах**
- Боловсролын байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авахаар төлөвлөсөн **100.0 сая** төгрөгийн задаргаа, боловсролын байгууллагуудаас ирүүлсэн санал, хэрэгцээ шаардлагын талаарх мэдээллийг аудитын хугацаанд ирүүлээгүй тул аймгийн ИТХ-д бэлтгэн танилцуулан, төсвийн хөрөнгийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах

2. Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт

²⁷ 6.3.3. хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

Аймгийн Засаг даргаас 2026 оны төсвийн төслийг ирүүлэхдээ УИХ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн засвар, арчилгааны зардалд баталсан 959.2 сая, 2025 оны хөрөнгө оруулалтын шилжих ажил 510.7 сая, нийт 1,469.6 сая төгрөгөөр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын саналыг бэлтгэн ирүүлсэн байна.

Хүснэгт 16. 2026 онд шилжих хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ байгуулснаас хойших хоног	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	Үлдэгдэл
1	Шинэ суурьшлын бүс үүсгэх зураг төсөв	2022-07-18	1226	22.5	15.8	6.7
2	Найрамдал хотхоны барилгуудын цахилгаан хангамжийн ажил	2022-06-13	1261	335.3	212.7	122.6
3	Найрамдал хотхоны нэг маягийн хүүхдийн талбайн зураг, төсөв	2024-04-16	588	8.9	4.4	4.4
4	Шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил	2025-09-17	69	785	553.0	232.0
5	Шинээр баригдах амины болон нийтийн орон сууцны барилгын дэд бүтцийн зураг төсөв	Тендер зарласан				55.0
6	Тэрбум мод усалгааны систем	Тендер зарласан				90.0
Нийт						510.7

(Эх сурвалж: АЗДТГ-аас ирүүлсэн судалгаа, хөрөнгө оруулалтын баримт)

Зураг төсвийн ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлэхгүй байгаагаас шалтгаалан дараа жилийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ зураг төсөвгүй хууль зөрчиж батлагдах шалтгаан болж байна.

1. Магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй хөрөнгө оруулалтын төсөл:

Хүснэгт 17. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй ажлын жагсаалт (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Зөрчил	Тайлбар
1	Аймгийн төвд авто зогсоол өргөтгөх ажил	300.0	Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 25.2.5, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын 3.2.2.2-т заасны дагуу сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагад нийцээгүй.	2024 онд 20.0 сая төгрөгөөр зураг төсөв боловсруулах төсөв нь батлагдсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.
2	1-15 дугаар байрны дундах тоглоомын талбайн тохижилт	259.8	Төсвийн тухай хуулийн 29.4, Барилгын тухай хуулийн 25.2.5, ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолын 3.2.2.2-т заасны дагуу сүүлийн 2 жилийн хугацаанд магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй байх шаардлагад нийцээгүй.	2024 онд 15.0 сая төгрөгөөр зураг төсөв боловсруулах төсөв нь батлагдсан боловч эцсийн байдлаар хүлээн аваагүй.
Нийт		559.8		

(Эх сурвалж: Аудитын ажлын баримт)

Хүснэгтээс харахад: 559.8 сая төгрөгийн 2 хөрөнгө оруулалтын төслийн зураг төсвийг 2024 онд гэрээ байгуулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн боловч гүйцэтгэл нь хангалтгүй байгаагаас 2026 оны төсөвт дахин магадлалаар баталгаажуулсан зураг төсөвгүй төлөвлөгдсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4²⁸, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3²⁹, Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5³⁰, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар

²⁸ 29.4.Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

²⁹ 13.3.3.техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

³⁰ 25.2.5.энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв.

хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.2.2³¹-т заасныг тус тус зөрчсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой аудитын санал, зөвлөмж:

1. Аймгийн төвд авто зогсоол өргөтгөх ажил 300.0 сая, 1-15 дугаар байрны дундах тоглоомын талбайн тохижилтын ажил 259.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төслүүдийн зураг төсөв барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгээгүй байх тул **хөрөнгө оруулалтын жагсаалтаас хасах**, шаардлага хангасан зураг төсөвтэй төсөл арга хэмжээг төлөвлөх

3. Авто замын сангийн төлөвлөлт

УИХ, Сангийн яамнаас авто замын санг 635.0 сая төгрөгөөр хянаж баталсан бөгөөд аймгийн ТЕЗ-аас 232.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 867.5 сая төгрөгөөр аймгийн 2025 оны төсвийн төсөлд тусгасан байна.

Нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл 2 шилжих ажлын санхүүжилт 212.5 сая, авто замын сангийн өөрийн орлого 20.0 сая нийт 232.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөжээ.

Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3³², 24.4³³, 24.5³⁴ дахь заалтууд, Засгийн газрын 2019 оны 312 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-аар авто замын сангийн хөрөнгийг зарцуулах эрх зүйн зохицуулалттай байна.

Хүснэгт 18. Авто замын сангийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, арга хэмжээний жагсаалт (сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Эхлэх/дуусах хугацаа	Төсөвт өртөг	2026 онд санхүүжүүлэх дүн
1. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт				
1.1	Аймгийн төвийн доторх авто замыг хэсэгчлэн засварлах	245.0	245.0	245.0
Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын дүн			-	245.0
2. Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ				
2.1	Зам арчилгаа, ажилчдын цалин хөлс, норм, нормативын зардал	360.0	360.0	360.0
2.2	Зам арчилгааны материалын зардал	50.0	50.0	50.0
Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ				410.0
3. Шилжих хөрөнгө оруулалт				212.5
3.1	Найрамдал хотхоны 6, 11 байрны өмнөх авто зам, зогсоолыг сайжруулах – Эн би деволлопмент ХХК	360.0	139.0	360.0
3.2	Найрамдал хотхоны 1, 15 дугаар байрны дундах хүүхдийн тоглоомын талбай – Эн би деволлопмент ХХК	73.5	73.5	73.5
НИЙТ ДҮН				867.5

(Эх сурвалж: аймгийн 2026 оны төсвийн төсөл)

³¹ 3.2.2.2.барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

³² 24.3.Улсын авто замын сангийн хөрөнгөөр олон улс, улсын чанартай авто замын, нийслэл, орон нутгийн замын сангийн хөрөнгөөр нийслэл, орон нутгийн чанартай авто замын арчлалт, засварын ажлыг тус тус санхүүжүүлнэ.

³³ 24.4.Авто замын сангийн хөрөнгөөр авто замын арчлалт, урсгал засвар, гэнэтийн хүчин зүйлээс хамаарсан засварын ажлыг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

³⁴ 24.5.Авто замын сангаас авто замын засвар, арчлалтын ажлыг хариуцсан байгууллагын үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажил хийх, техник технологийг шинэчлэх, хөндлөнгийн хяналт тавих, хөдөлгөөнт эргүүл ажиллуулах, мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх, авто замын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлнэ.

2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын болон арга хэмжээний зардлууд нь Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан чиг үүрэгтэй нийцсэн байна.

Авто замын сангийн төлөвлөлттэй холбоотой аудитын санал, зөвлөмж:

1. Магадлалаар баталгаажсан төсвөөс зардлын түүвэр хийж хэсэгчлэн гүйцэтгэхээр төлөвлөсөн 245.0 сая төгрөгийн 1 хөрөнгө оруулалтын ажлын төсөвт өртгийг баталгаажуулж, төсвийн хөрөнгийн төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах

4. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ

Орон нутгийн 2026 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийн 2 дугаар зүйлийн 2.4-т “Сангийн яам хянаж, Засгийн газраас өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал баталсан түвшнээс бууруулахгүйгээр орон нутгийн төсөвт тусгаж батлуулах” чиглэлийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас 2026 оны орон нутгийн төсвийн суурь зарлагад тус арга хэмжээний зардлыг 246.4 сая төгрөгөөр хянасан бөгөөд уг дүнгээр аймгийн төсвийн төсөлд тусгасан ба БХНСАХЗ-аас аймагт буюу БОГ-т 88.5 сая, Сүмбэр суманд 121.4 сая, Шивээговь суманд 25.8 сая, Баянтал суманд 10.7 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2026 оны төсвийн төсөлд Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардалд онд шинээр хэрэгжүүлэх 3 ажилд 35.0 сая, 9 арга хэмжээнд 53.5 сая нийт 88.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлттэй холбоотой аудитын санал, зөвлөмж:

1. Шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлын тооцоо, судалгааг бэлтгэж аймгийн ИТХ-д танилцуулах, төлөвлөлтийн үр ашгийг сайжруулах

Аймгийн ОНХС, ОНТХО, АЗС, БХНСАХЗ-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний төлөвлөгөөг дараах байдлаар сайжруулах, хууль нийцүүлэх санал гаргав.

- Магадлалаар баталгаажсан зураг, төсөвгүй “Шинэ суурьшлын бүсийн хэсэгчилсэн цахилгаан хангамж” 450.0 сая, Аймгийн төвд авто зогсоол өргөтгөх ажил 300.0 сая, 1-15 дугаар байрны дундах тоглоомын талбайн тохижилтын ажил 259.8 сая, **нийт 1,009.8 сая төгрөгийн 3 хөрөнгө оруулалтын ажлыг хасах**, өөр шаардлага хангасан зураг, төсөвтэй ажил төлөвлөх
- Магадлалаар баталгаажсан төсвөөс зардлын түүвэр хийж хэсэгчилсэн байдлаар гүйцэтгэхээр төлөвлөсөн **1,555.1 сая** төгрөгийн төсөвт өртөгтэй **5 ажлын төсвийг** мэргэжлийн байгууллагаар баталгаажуулж **төсвийн үр ашгийг сайжруулах**
 1. Баянтал суманд баригдах спорт заалны өргөтгөл-600.0 сая ,
 2. Тагт, Гашууны эгнээний 0.4кВ цахилгаан шугамын өргөтгөл-200.0 сая
 3. Усан бассейны үлдэгдэл ажил /сантехник, агааржуулалт, фитнес заал, гадна паднус/- 310.1 сая
 4. Сүмбэр суманд автозамын дагуу гэрэлтүүлэг, явган замын ажил (Өгөөж)-200.0 сая
 5. Аймгийн төвийн доторх авто замыг хэсэгчлэн засварлах 245.0 сая нийт 1,551.1 сая
- Боловсролын байгууллагуудад тоног төхөөрөмж худалдан авах 100.0 сая төгрөгийн арга хэмжээг Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.3.3-т нийцүүлэн төлөвлөж төсвийн үр ашгийг сайжруулах

- Засаг даргын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг оновчтой тодорхойлох, гүйцэтгэлийн үр дүнг бодитой хэмжигдэхүйц, нийгэм эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх байдлыг тоон болон чанарын үзүүлэлтээр боловсруулах

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 63.3 хувьтай хэрэгжилт хангалтгүй байна.

Хүснэгт 19. 2025 оны орон нутгийн төсвийн төслийн аудитаар дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

№	Зөвлөмжийн утга	Биелэлт	Хэрэгжилт хувиар
1	Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу 18 дугаар зүйлийн 18.5, 18.6-т заасан хугацаанд боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулах	Аймгийн Засаг даргын 2025.09.29-ний өдрийн А/946 тоот албан бичгээр аймгийн 2026 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг АИТХ-д хүргүүлсэн боловч хэлэлцэж батлаагүй.	70%
2	ОНХО, ОНХС, Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгахгүй байх, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний зураг төсвийг боловсруулж батлуулах, зардлын задаргаа, ажлын даалгавар, холбогдох тооцоо судалгааг иж бүрэн гаргах, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэх	Магадлалаар эцэслэн батлагдаагүй зураг төсөвт үндэслэн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй ажлыг төлөвлөсөн тул хэрэгжилтийг хангалтгүй гэж дүгнэсэн. Харин 2026 оны төсөвт авто замын сан, ОНХС, ОНТХО-г хуульд заасан чиг үүргийн дагуу төлөвлөсөн байна.	60%
3	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн зураг төсвийн ажлыг хүчинтэй байх хугацаанд нь буюу 2 жилийн дотор ашиглах, улсын төсөвт тусгуулж хэрэгжүүлэх ажлын зураг төсвийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол зэргийг харгалзсаны үндсэн дээр боловсруулах, өмнө хийгдсэн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулахгүй, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, төсвийн хөрөнгийн үр ашгийг тооцоогүй хөрөнгийг давхардуулан авахаар төлөвлөхгүй байх	2025 оны төсвийн төслийн аудитаар “1-15 дугаар байрны тоглоомын талбай”, “аймгийн төвд авто зогсоол барих” ажлууд магадлалаар батлагдсан зураг төсөвгүй байсан бөгөөд, эцсийн байдлаар хүлээж аваагүй байна.	60%
Нийт			63.3%

Аудитаар орон нутгийн 2025 оны төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх 2,452.1 сая төгрөгийн 6, зардлыг бууруулах 1,414.0 сая төгрөгийн 6, төсвийн санхүүжилтийн үр ашгийг сайжруулах 1,721.6 сая төгрөгийн 7 санал, нийт 5,587.7 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн үр ашгийг сайжруулах саналыг гаргаж, аймгийн ИТХ, Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСӨВТ ТАТВАРЫН ХУРИМТЛАГДСАН ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ ЗАМААР 2,452.2 САЯ ТӨГРӨГИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.
2. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ АЙМГИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТЭЙ АГУУЛГЫН ХУВЬД НИЙЦЭЖ БАЙНА.
3. ТАТВАРЫН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.
4. ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИАР БАТАЛСАН ОРЛОГЫН ДООД ХЭМЖЭЭНИЙ ХЯЗГААРЫГ ЗӨРЧИЖ, 2 НЭР ТӨРЛИЙН ТАТВАРЫН ОРЛОГЫГ ТӨСВИЙН ТӨСӨЛД 132.5 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛСАН, ТАТВАРЫН ХУРИМТЛАГДСАН ӨР ТӨЛБӨРИЙГ БОДИТОЙ ТООЦОЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.
5. АЙМГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД УРСГАЛ ЗАРЛАГЫГ 404.2 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖТОЙ БАЙНА.
6. ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ, ҮР АШИГТАЙ, ХУУЛЬ ТОГТООМЖИД БҮРЭН НИЙЦҮҮЛЖ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.
7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГАД БҮРЭН НИЙЦЭЭГҮЙ НИЙТ 2,664.9 САЯ ТӨГРӨГИЙН 6 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.



ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн аймгийн 2026 оны төсвийн төсөлд орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, төсвийн үр ашгийг сайжруулах чиглэлээр нийт 5,587.7 сая төгрөгийн дараах саналыг хүргүүлж байна.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД:

1. Орлогыг нэмэгдүүлэх санал-2,452.1 сая
2. Төсвийн зарлагыг бууруулах – 1,414.0 сая
 - 2.1 Урсгал зардлыг бууруулах-404.2 сая
 - 2.2 Орон нутгийн хөгжил сан, Хөрөнгө оруулалтын зардал бууруулах – 1,009.8 сая
төгрөгийн 3 хөрөнгө оруулалтын төсөл
3. Төсвийн үр ашгийг сайжруулах – 1,721.7 сая
 - 1.1 Орон нутгийн хөгжлийн сан-1,410.1 сая төгрөгийн 3 хөрөнгө оруулалтын төсөл
 - 1.2 Автозамын сан- 245.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
 - 1.3 Тэтгэмж-Төрийн үйлчилгээний албанаас орон тооны цомхотголоор чөлөөлөгдөх албан хаагчдад олгох тэтгэмжийн зардал 66.6 сая төг

Хавсралт 1.

2026 оны суурь орлогын тооцоолол

(мянган төгрөг)

Төсвийн орлого	Сангийн яамнаас хянасан 2026 оны суурь орлого	Аймгаас өөрчлөлт оруулах санал	Өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн 2026 оны суурь орлого
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	12,750,000.0	-	12,750,000.0
Үйл ажиллагааны орлого	200,000.0	- 50,000.0	150,000.0
Хөрөнгийн орлого	590,000.0		590,000.0
Хөрөнгийн борлуулсны орлого	290,000.0		290,000.0
Бусад татвар /Шууд бус орлого/	220,000.0	200,000.0	420,000.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 700,000.0		- 700,000.0
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	819,000.0		819,000.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	700,000.0	46,000.0	746,000.0
Бууны албан татвар	5,000.0		5,000.0
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	127,000.0	24,000.0	151,000.0
Улсын тэмдэгтийн хураамж	90,000.0	30,000.0	120,000.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	30,000.0	15,000.0	45,000.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	218,000.0		218,000.0
Газрын төлбөр	680,000.0	200,000.0	880,000.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	335,534.5	- 82,534.5	253,000.0
Дуудлага худалдаа		1,033,000.0	1,033,000.0
Малын тоо, толгойд ногдох албан татвар	-	-	-
Ан амьтны нөөц ашигласны албан татвар	95,740.0	-	95,740.0
Татварын орлогын дүн	16,450,274.5	1,415,465.5	17,865,740.0
Торгуулийн орлого	1,200,000.0	300,000.0	1,500,000.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	20,000.0	381,000.0	401,000.0
Түрээсийн орлого	150,000.0	50,000.0	200,000.0
Татварын бус орлогын дүн	1,370,000.0	731,000.0	2,101,000.0
НИЙТ СУУРЬ ОРЛОГЫН ДҮН	17,820,274.5	2,146,465.5	19,966,740.0